



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭН

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, Баруун сэлбэ 15-4, И-мэйл: igg@mas.ac.mn  
Утас: 325487, 329583, 322187 Факс: 976-1-322187

2023.11.07 № 1/495

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
(МУИС) ДЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ  
URGENT ТӨСӨЛД

Хичээлийн хөтөлбөрт ажил олгогчийн санал  
өгөх тухай

Монгол Улсын Их Сургууль (МУИС) дээр хэрэгжиж буй URGENT төслийн хүрээнд боловсруулж буй “Тогтвортой хөгжил” цахим хичээлийн хөтөлбөртэй манай хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын ЭША П.Цэенханд тэргүүтэй судлаачид танилцаж, доорх саналууд гаргасныг хүргүүлж байна. Юуны өмнө Тогтвортой хөгжлийн тухай үзэл баримтлал нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлого юм. Иймд “Тогтвортой хөгжил” хичээлийн хөтөлбөр нь дэлхийн улс орнууд байгаль орчиндоо ээлтэй технологи хөгжүүлэх, хөгжлийн түвшний шалгуур үзүүлэлт боловсруулах, олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн үзэл баримтлал, олон улсын хүрээлэн буй орчны эрхзүйн шинэчлэл, хөгжлийн талаар цогц мэдлэг олгохоос гадна суралцагч нарт судалгааны үр дүн боловсруулах, мэдээ баримт цуглуулах, ангилан ялгах, нэгтгэн дүгнэх, олон улсын болон дотоодын байгаль орчны болон нийгмийн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байх ёстой. Үүнийг хичээлийн хөтөлбөрийн агуулга хангасан байна.

Нөгөөтэйгөөр тус хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбар нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн үйл явц, өөрчлөлт, шинэчлэлд дүн шинжилгээ хийж, бүс нутгийн төлөвлөлт, улс орны ирээдүйн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, аж үйлдвэрийн төлөвлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, ажиллах хүчний үнэлгээ зэрэг улс орны эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг илрүүлэх, шийдвэрлэх арга боловсруулах чиглэлүүдийн хүрээнд судалгааны ажил гүйцэтгэдэг. Их, дээд сургууль төгсөгчдөөс тус салбарт ажиллах үед судалгааны аргазүй эзэмших, дүн мэдээнд шинжилгээ хийх, олон улсын болон дотоодын нийгэм, эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийх ур чадварууд шаардлагатай байдаг. Иймд олон нийтийн боловсролд зориулан МУИС-ийн “Сургалтын журам”-ын дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж буй уг хичээлийн хөтөлбөрт дараах зүйлсийг анхаарч үзвэл зохистой. Үүнд:

а. Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нь судалгаа шинжилгээний ажилд туслан болон үндсэн гүйцэтгэгчээр оролцохоос гадна байгаль,

2023424

газарзүйн нөхцөл, нөөцийн талаарх суурь мэдлэг, дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшин, эдийн засаг, нийгмийн бүтэц, улс төр, соёлын талаар өргөн мэдлэгтэй байх шаардлагатай тул улс орнуудын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хэрэгжилттэй холбоотой сэдвүүдийг лекц, семинарын агуулгад багтаах

б. Эрдэм шинжилгээний ажилтанд судалгааны шинжилгээний бүтээлтэй танилцах, дүгнэлт хийх, авч ашиглах, боловсруулах ур чадвар шаарддаг тул хичээлийн семинарын агуулгад судалгааны мэдээ, материал цуглуулах, анхдагч дүн шинжилгээ хийх ур чадваруудыг хөгжүүлэх талаар мөн тогтвортой хөгжлийн 17 зорилтын биелэлтэд үнэлэлт өгөх чадвар суулгах, Монгол Улсын хөгжлийн дунд болон урт хугацааны тайлангуудтай танилцах зэрэг сэдвүүдийг багтааж өгөх нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

САНАЛ ӨГСӨН:

ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
НЭЭГЗ САЛБАРЫН ЭШДА, ДОКТОРАНТ

*П. Цэенханд*

П.ЦЭЕНХАНД

САНАЛ БАТАЛГААЖУУЛСАН:

ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ, ДОКТОР

*А.ДАШЦЭРЭН*

